



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага





Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

УЛИРЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

(2023 ОНЫ УЛИРАЛ III)



А БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

Үр дүнд суурилсан төлөвлөлт

Төслийн зүгээс Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-ны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газартай хамтран 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулахад мэргэжил, аргагүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Үр дүнд суурилсан төсөвлөлт

Төсөл нь 2024 оны төсвийн саналаа үр дүнд суурилсан байдлаар боловсруулахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ), Соёлын яам (СЯ), Үндэсний Аудитын газар (ҮАГ) болон Биеийн тамир спортын улсын хороо (БТСУХ)-нд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Энэ дэмжлэгийн хүрээнд СЯ-наас Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ) нарт бэлтгэн хүргүүлдэг 'Төсвийн төслийг бэлтгэх удирдамж'-ид саналаа боловсруулан хүргүүлж, сонгосон яамдын төсвийг үр дүнд суурилсан (ҮДСТ) аргачлалаар бэлтгэхэд хэрэглэх төсвийн саналын маягтууд, холбогдох зааврыг 2023 оны 7 дугаар сарын 5-нд хүргүүлсэн.

[Мэдээ унших холбоос](#)



Энэ жилийн хувьд орон нутгийн төсвийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулахад ашиглах маягт, зааврыг Дорноговь аймгийн сонгогдсон хөтөлбөрийн хүрээнд туршин боловсруулж, 2024 оны төсвийн удирдамжид хавсарган хүргүүлсэн.

[Мэдээ унших холбоос](#)

Дараах хөтөлбөрүүдийн төсвийн саналыг үр дүнд суурилсан аргачлалын дагуу боловсруулан СЯ-нд хүргүүлж, холбогдох хэлэлцүүлгийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Үүнд:





Зураг 1. “Үр дүнд суурилсан удирдлага” сургалт семинар, Дорноговь аймаг, 2023.09.21

Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-той уялдсан үр дүнд суурилсан удирдлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймгийн, аймаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-ын төлөөлөгч, ИТХ-ын ажлын албадын чадавхийг “Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт”-ийн чиглэлээр бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

 [Мэдээ унших холбоос](#)

НОТОЛГООНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТ

ТХЗ-ын тэргүүлэх салбаруудын хөтөлбөрийн бодлого, төсвийг уялдуулан үр дүнд суурилсан төлөвлөлтөд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, нотолгоонд суурилсан төсөв боловсруулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор дараах салбарын зарлагын шинжилгээ хийж байна. Үүнд:



Соёлын салбарын
хөтөлбөрт институцийн
болон зарлагын
шинжилгээ



Хүүхэд хамгааллын
хөтөлбөрийн төсвийн
зарлагын шинжилгээ



Биеийн тамирын
салбарын төсвийн
зарлагын шинжилгээ

ҮР ДҮНД СУУРИЛСАН ТАЙЛАГНАЛТ

Бүх шатны төсвийн байгууллагад мөрдөгдөх ‘Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг тайлагнах заавар, маягт, аргачлал’-ын төслийг боловсруулан хуулийн зөвлөхөөр хянуулан СЯ-ны төрийн сангийн газарт хүргүүлэв.

Гүйцэтгэлийн тайлангийн агуулга, маягт, загварын дагуу ХНХЯ болон ХХААХҮЯ-ны 2023 оны хагас жилийн үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайланг туршиж, үр дүнгийн тайлан бэлтгэсэн ба холбогдох яамдтай хэлэлцүүлэг хийсэн.

Б БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

УИХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Төсвийн байнгын хорооны захиалгаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахад техник туслалцаа үзүүлэн ажилласан ба хуулийн өөрчлөлт 2023 оны 8 дугаар сарын 24-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна. Мөн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх ажлын даалгаврын төслийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зарлаад байна.

Хөдөө аж ахуй (ХАА)-н дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан, ХЭД бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээний танилцуулгыг УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтэс (ТХШХ)-ийн албан хаагчдад танилцуулж холбогдох арга, аргачлалын материалыг хүлээлгэн өгсөн.

Мөн УИХ-ын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтэс болон Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн холбогдох албан хаагчдад ҮАГ-ын 2024 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулсан туршлагыг жишээ болгон танилцуулсан. Тус байгууллагын аргачлалд тулгуурлан УИХ-ын Тамгын газар 2025 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулахаар санал солилцов.

Төсвийн хяналтын сонсгол, олон нийтийн хэлэлцүүлгийн өнөөгийн байдлыг судалж “Төсвийн хяналтын сонсгол ба төсвийн нээлттэй хэлэлцүүлэг” сэдэвт гарын авлагын төслийг боловсруулсан.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД (ИНБ)-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

ҮАГ болон ИНБ-уудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцагч талуудын оролцооны стратегийг хангах, ИНБ-уудын хяналт чиг үүргийг сайжруулах чиглэлд төслийн зүгээс ИНБ-ын оролцоог хангах ажлыг 2 үе шаттайгаар төлөвлөн ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд дараах алхмуудыг авч хэрэгжүүлэх ба үүнд

- 1) бодлого төлөвлөлт, төсөвлөлтийн чиглэлээр сургалт, чадавх бэхжүүлэх арга хэмжээнд хамруулах;
- 2) Төрийн аудитын тухай болон УИХ-ын хяналт шалгалтын тухай хуульд заасан ҮАГ-ын хуулийн хугацаатай хэрэгжүүлдэг аудитын үйл ажиллагааны холбогдох үе шатны ажилд оролцуулах зэргийг багтаасан болно.

Энэхүү ажлын хүрээнд ҮАГ-аас 2024 оны төсвийн төсөлд аудит хийх ажилд төсвийн бодлого, төсвийн орлого, зарлага төлөвлөлт, Засгийн газрын өр, МУ-ын нэгдсэн төсвийн тэнцэлд судалгаа, хөндлөнгийн шинжилгээ хийлгэхээр мэргэшсэн ИНБ-ыг сонгон авч хамтран ажиллаж эхэлсэн. Хяналт шинжилгээ хийдэг ИНБ-ын санал бодлыг энэхүү судалгаа шинжилгээний тайланд тусгах зорилгоор 12 ИНБ-тай уулзаж, санал бодол солилцлоо.

ҮАГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Төрийн бодлогод үнэлгээ хийх, аудит хийх дараах гарын авлагуудыг орчуулж, бодлогын дэмжлэг үзүүлсэн. Үүнд:



Үндэсний Түлхүүр
Индикаторуудын
боловсруулалт болон
ашиглалтад аудит хийх
удирдамж 5290



Төрийн бодлогын
үнэлгээ хийх
удирдамж 9020

МУ-ын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд аудит хийх үйл ажиллагаанд ИНБ-ыг оролцуулж, салбарын шинжилгээ хийлгэх чиглэлээр ҮАГ-тай хамтран ажилласан.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Дагалдан ажилтанг ажлын байранд дадлагажуулах замаар ажилтан, ажил олгогчийг дэмжих туршилтын төслийг ХНХЯ-тай хамтран боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (ХЭҮЗ)-өөр батлуулсан. Энэхүү туршилтын төсөл 2023-2024 онд 11,8 тэрбум төгрөгийн төсвөөр нийт 5,000 иргэнд ажил олгогчийн захиалгад үндэслэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд нийслэл, орон нутгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл болон “Шинэ сэргэлтийн бодлого”-той нягт уялдан хэрэгжих юм.



Зураг 2. “Хуримтлалын нэгдсэн сангийн хуулийн төслийн хэлэлцүүлэг, 2023.10.27

“Хөдөлмөрийн зах зээлийн нөлөөллийн үнэлгээ хийх” арга зүйн төслийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ) болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (ХНХСҮСИ)-тэй хамтран боловсруулж, мэдээлэл цуглуулах ажлыг эхлүүлээд байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бизнес эрхлэгчдэд зориулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-аас олгож буй эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн сонгон шалгаруулалтын үйл явцыг оновчтой, энгийн болгож, бизнес бойжуулах, мөн хурдасгуур төв байгуулах зэрэг санхүүгийн бус дэмжлэгийг бий болгоход чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил хийгдэж байна.

ХНХЯ-тай хамтран Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа, үзэл баримтлал, хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслийг боловсруулан ХНХЯ-нд хүргүүлээд байна.



Зураг 3. “Боловсролын шинэ сэргэлт” семинар, 2023.09.24

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй салбарын үр дүнг уялдуулах зөвлөмж гаргаж, 2023 оны 8 дугаар сарын 23, 24-ны өдрүүдэд төрийн болон хувийн өмчийн 77 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (МБСБ)-ын захирал, арга зүйч, нягтлан бодогч бүхий нийт 350 хүнийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан.

[Мэдээ унших холбоос](#)



Зураг 4. Баянчандмань Политехник Коллежийн хүртээмжтэй сургалтын орчин

“Энтрепренершип ба бизнес эрхлэх үр чадвар” чадамжид суурилсан сургалтын 40 цагийн хөтөлбөрийг ХНХЯ болон ХНХСҮСИ-тэй хамтран боловсруулсан. Уг хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, удирдлага, арга зүйгээр хангах зорилгоор “Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамж”-ийг боловсруулж, сургалт зохион байгуулах нөхцлөөр хангаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 2023-2024 оны хичээлийн жилд “Цахим үйлчилгээний ажилтан” мэргэжлээр шинэ анги нээх, тусгай хэрэгцээтэй оюутнуудад хүртээмжтэй орчин бүрдүүлсэн улсын хэжээний жишиг болгохоор ажиллаж байна.

[Видео үзэх холбоос](#)

2023 онд Үндэсний Мэргэшлийн Хүрээг (ҮМХ) боловсруулан батлуулахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-д дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд ҮМХ, хэрэгжүүлэх зураглал, холбогдох журам, аргачлалыг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУРШИЛТЫН ТӨСЛҮҮД (НҮБ-ЫН ХХААБ)

“Agripreneurship Challenge” тэмцээний үргэлжлэл инкубатор хөтөлбөрийн хүрээнд “Мэжик би фүүдс” ХХК-ийн зөгийн хортой эрүүл мэндийн тосны төрлийг нэмэгдүүлж гарын тос болон уруулын тэжээлийн тос гаргах судалгааны ажлыг эхлүүлээд байна. Харин Спек материалс ХХК нь сарлагийн хөөвөрийг аргалтай хольж шинэ төрлийн цаас гаргахаар ажиллаж байна. Мөн хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн 30 гаруй гарааны бизнес эрхлэгчдэд “Олон улсын худалдаа, экспортын стратеги” сэдэвт 3 өдрийн сургалтыг зохион байгуулж инновацийн төсөл түүнд хэрхэн хамрагдах арга зүй, гадаад худалдааны гэрээ, нийтлэг алдаа, ололт амжилтын туршлага, экспортын бэлэн байдлын үнэлгээ зэрэг сэдвүүдээр мэдлэг, мэдээлэл олголоо.

[Мэдээ унших холбоос](#)



Зураг 5. “Agripreneurship Challenge” тэмцээний шилдэг оролцогчдыг ХХААБ, ОУХБ болон НҮБХХ-ын ажилтнуудад танилцуулах эвент



Зураг 6. Намрын ногоон өдрүүд 2023 үзэсгэлэн



Зураг 7. Улаанбаатар түншлэл 2023 үзэсгэлэн

Бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг өсгөх, олон нийтэд танигдах байдлыг дэмжих зорилгоор нийт 7 компанийг Намрын Ногоон Өдрүүд 2023 болон Улаанбаатар түншлэл 2023 үзэсгэлэн худалдаанд оролцуулсан. Түүнчлэн, “Agripreneurship Challenge” тэмцээний шилдэг оролцогчдын үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч ХХААБ, ОУХБ болон НҮБХХ-ын ажилтнуудад танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.

[Мэдээ унших холбоос](#)

Дотор махны бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажлын хүрээнд ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль болон Монголын Махны Холбоо (ММХ) – той хамтран ажиллаж байна. Мөн мах боловсруулах салбарын тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх арга зам болон тус салбарыг экспортын чиг баримжаатай хөгжүүлэхэд гаргаж буй шийдэл, сүүлийн үед хийж буй ажлуудын талаар холбогдох талуудтай хэлэлцсэн юм.

Харин хагас эрчимжсэн ингэний аж ахуй байгуулах ажлын хүрээнд төслийн баг Өмнөговь аймгийн Ханхонгор, Ханбогд суманд ажиллах явцад Solid Partners Group LLC-ийн барьж буй хагас эрчимжсэн ингэний аж ахуйн үйл явцтай танилцан хэрэгцээт тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгч, техник арга зүйн зөвөлгөө өгсөн.

[Мэдээ унших холбоос](#)

Мөн төслийн баг Ази тивийн сүүний түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газар, ХХААХҮЯ, Европын Холбооны “Олон улсын худалдааг дэмжих” төсөл болон Монгол бактриан нийгэмлэгтэй хамтран “Монгол улсад ингэний сүүний кластер байгуулах боломж, арга зам” сэдэвт ажил хэргийн уулзалтыг зохион байгуулж ингэний сүүний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх боломж болон экспортын нэгдсэн бодлого хэрэгжүүлэх талаар хэлэлцлээ.

Бизнес төлөвлөгөө боловсруулахад зориулсан “Хөдөөгийн хөрөнгө оруулалт” сэдэвт 5 хоногийн сургалтыг Хэнтий аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулсан. 2023 онд тус сургалтад нийт 153 жижиг, дунд бизнес эрхлэгч хамрагдаж, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийх, борлуулалтын төлөвлөгөө гаргах чадвартай болж РуралИнвест “RIV-20” иж бүрэн програм хангамжийг цаашид үнэ төлбөргүй ашиглах боломжтой болж байгаа юм.

[Мэдээ унших холбоос](#)

D БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

2023 оны 9 дүгээр сарын 27, 28-ны өдөр зохион байгуулсан сургалтаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын ахлах байцаагч нарын чадавхыг дараах чиглэлээр бэхжүүллээ. Үүнд:



Зураг 8. Удирдах ажилтнуудын чадавх бэхжүүлэх сургалт семинар, 2023.09.27-28



Салбарын хяналтын чиглэлээр баримталж буй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;



Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;



Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөх, зохион байгуулах чиглэлээр техник арга зүйгээр хангах;



Олон улсын хөдөлмөрийн хяналтын хэм хэмжээг хэрэгжүүлэх.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолоор Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх 162 улсын байцаагч тус яаманд шилжин ирж, харьяа агентлаг, нийслэл, аймаг, дүүргийн төрийн захиргааны байгууллагад чиглэл тус бүрээр томилогдон ажиллаж байна.



Зураг 9. Дижитал шийдлийн Хакатон арга хэмжээ 2023.09.29

Монгол Улсад залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг технологи ашиглан шийдвэрлэх, залуучуудад зориулсан зохистой хөдөлмөрийг дэмжих шинэлэг шийдлүүдийг боловсруулж турших, залуучуудын зохистой хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрлөх эрхийг хамгаалахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой Дижитал шийдлийн хакатон арга хэмжээг зохион байгууллаа.

[Мэдээ унших холбоос](#)

Энэ удаагийн хакатонд сэтгүүл зүй, мэдээллийн технологи, иргэний нийгэм, хувийн хэвшил, болон МСҮТ-ийн оюутан залуус, багш ажилчид, залуучуудын төлөөлөл бүхий нийт 48 баг бүртгүүлснээс, тодорхой шалгуур үзүүлэлт хангасан 12 баг шалгарсан бөгөөд 2023 оны 9 дүгээр сарын 27-нд шилдэг дараах гурван төслийг шалгаруулав. Үүнд:

1-Р
БАЙР

“Law and Tech” баг

Залуучуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх цахим тоглоом

(2,000,000 төгрөг)

2-Р
БАЙР

“Team NZ” баг

Хиймэл оюун ухаан ашиглаж залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох платформ

(1,500,000 төгрөг)

3-Р
БАЙР


“Optimal NMax” баг

Ажлын байрны сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах дижитал шийдэл

(1,000,000 төгрөг)

Эхний хоёр байранд шалгарсан төслүүдэд нийт **3,000 ам.долларын** тэтгэлэг олгож, төслийн хэрэгжилтийг дэмжин ажиллаж байна.

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН ТҮҮХЭЭС



Төслөөс олгосон санхүүгийн дэмжлэгээр мал угаалгын шинэлэг үйлчилгээг малчны хот айлд хүргэж буй “Чандмань Алтан төл” хоршооны видео

[Видео үзэх холбоос](#)

2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН ТАЙЛАН



[Тайлан татах](#)



[Тайлан татах](#)



[Тайлан татах](#)



[Тайлан татах](#)



Төслийн холбоо барих хаяг

Монгол Улс, Улаанбаатар 14201
Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж - 14
Нэгдсэн Үндэстний байр
Утас: 976-11-32785

[Вэб хуудас](#)

[Фэйсбүүк](#)

[Twitter](#)